



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

140

1970 оны 12 дугаар сарын 07 өдөр

Дугаар 6-24/2

Улаанбаатар хот

Мэргэжлийн комиссыг шинэчлэн байгуулах тухай

1. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хот байгуулалт, газрын харилцаатай холбоотой бусад асуудлыг зохицуулах, мэргэжлийн талаас иж бүрэн шийдвэрлэх, Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

- | | |
|-----------------------|---|
| Комиссын дарга | - Нийслэлийн Захирагчийн ажлын албаны дарга, хотын ерөнхий менежер |
| Орлогчид: | - Хот байгуулалт, инженерийн байгууламжийн хэлтсийн дарга, хотын ерөнхий архитектор
- Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн албаны дарга, Улаанбаатар хотын газрын ерөнхий даамал |
| Нарийн бичгийн дарга: | - Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн албаны орлогч дарга |
| Гишүүд: | - Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн орлогч дарга
- Хот байгуулалт, инженерийн байгууламжийн хэлтсийн дулааны инженер
- Өмчийн газрын дарга
- Хот тохижилтын хэлтсийн дарга
- Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга
- Байгаль орчныг хамгаалах газрын дарга
- ДШСГазрын ерөнхий инженер
- УСАУ газрын ерөнхий инженер
- ЦШСГазрын ерөнхий инженер
- ГХГ-ын ерөнхий инженер
- ГТТГ-ын хэлтсийн дарга
- ЭАХСХ-ын албаны дарга
- ОСНААК-ний ерөнхий инженер |

2. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссын дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

3. Нийслэлийн Засаг даргын "Мэргэжлийн комисс байгуулах тухай" 1995 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/283 тоот, "Техникийн байнгын зөвлөл байгуулах тухай" 1994 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/35 тоот захирамжуудыг тус тус хүчингүй болгонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.Наранцацралт Ж.НАРАНЦАЦРАЛТ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН КО-
МИССЫН ДҮРЭМ

УХС 11

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комисс (цаашид комисс гэнэ) нь нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, батлагдсан ерөнхий төлөвлөгөө болон газрын тухай Монгол улсын хуульд нийцүүлэн барилга байгууламж барих, газар ашиглуулах, эзэмшүүлэх болон газрын харилцаатай холбоотой бусад асуудлыг зохицуулах үйл ажиллагааг мэргэжлийн талаас нь иж бүрэн шийдэхэд оршино.

1.2. Комисс нь үйл ажиллагаандаа Барилга, хот байгуулалтын хууль, Газрын тухай хууль, Нийслэлийн нутаг дэвсгэр дээр газар ашиглуулах, эзэмшүүлэх тухай журам, Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдлөг болгож ажиллана.

1.3. Комисс нь орон тооны бус гишүүдтэй ажиллах бөгөөд тэдгээрийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

1.4. Комисс нь албан бланк, тэмдэгтэй байна.

Хоёр. Комиссын эрх үүрэг

2.1. Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөлд үндэслэн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, түүнд хяналт тавих, тодотгол хийх, тухайлсан орон зай, эзэлхүүн төлөвлөлт, байршлыг тогтоох, шийдвэрлэх.

2.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт улсын болон бүс нутаг, хотын чанартай зам тээврийн сүлжээ, инженерийн байгууламж, шугам сүлжээг хэтийн төлөвтэй уялдуулан барьж байгуулах, хяналт тавих, сайжруулах, шинэчлэх, өргөтгөхөд дүгнэлт гаргах, шийдвэрлэх.

2.3. Газар эдлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эдлэх эрхийг баталгаажуулах, тухайн газрыг ашиглах, эзэмших хэлбэр, зориулалт, горимыг тогтоох дүгнэлт гаргах.

2.4. Ашиглуулах, эзэмшүүлэх газрын хип, зааг, хэмжээ, хугацааг тогтоож акт гаргах.

2.5. Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, гадаадын болон улсын хөрөнгө оруулалттай, ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төсөл, архитектурын онцлог шийдэл бүхий томоохон барилга, байгууламжийг барих, тэдгээрт газар эзэмшүүлэх, баталгаажуулах асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлэх.

2.6. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайлсан орон зайд баригдах барилга, байгууламжуудын байршлыг тогтоох, газар ашиглах, эзэмших эрхийг баталгаажуулах асуудлаар шийдвэр гаргах.

2.7. Газар эзэмших, ашиглах эрхийг зохих болзол нөхцлийн дагуу төсөл уралдуулан шалгаруулах.

2.8. Комисс нь хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагаас албан ёсны санал, дүгээлт гаргуулах.

2.9. Барилга, хот байгуулалтын хууль, Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг арилгуулах, газар ашиглах, эзэмших эрхийг дуусгавар болгож, газрыг чөлөөлөх талаар холбогдох байгууллагуудад үүрэг өгөх.

Гурав. Комиссын үйл ажиллагаа

3.1. Комисс нь сард 2-оос доошгүй удаа хуралдаж олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

3.2. Комиссын хуралд хэлэлцэх барилгын байршлын схем, газрын баталгаажилтын схемийг загварын дагуу бүрдүүлнэ.

3.3. Хуралд хэлэлцэх материалыг комиссын нарийн бичгийн дарга, гишүүдэд хурал хуралдахаас 5 хоногийн өмнө тарааж танилцуулна.

3.4. Комисс нь шийдвэр гаргахдаа хот суурин, зам шугам сүлжээний ангиллын газарт ХБИБ хэлтсийн, бусад ангиллын газрын хувьд ГХҮХХБ Албаны боловсруулсан ерөнхий төлөвлөгөө, зурвг төсөл, тооцоо судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, тодорхойлолт зэргийг үндэслэнэ.

3.5. Комиссын нарийн бичгийн дарга хурлын материал бүрдэлтийг шалган хэлэлцэх асуудлын жагсаалтыг комиссын даргаар батлуулан гишүүдийн ирц, хуралдааны үйл ажиллагаа, гишүүдийн хэлсэн үг, гарсан санал шийдвэрийг хуралдааны протоколд тодорхой тусгаж материалыг архивт хадгалуулна.

3.6. Гишүүдийн хуралд оролцсон байдал, идэвх санаачилгыг харгалзан тэдэнд урамшуулал олгоно.